

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/37/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Иймэл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/77
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Т.БААТАРМӨНХ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020278

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	861,200.00	709,182.00
35	БАРАА МАТЕРИАЛ	861,200.00	709,182.00
354	Хангамжийн материал	861,200.00	709,182.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	51,000.00
35420	Аж ахуйн материал	96,200.00	28,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	765,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	630,182.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	46,805,487.36	26,978,809.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	46,805,487.36	26,978,809.56
392	Биет хөрөнгө	46,585,487.36	26,813,809.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,490,000.00	23,490,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,556,666.68	-9,056,666.69
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,795,286.00	1,795,286.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-598,428.72	-1,047,250.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	240,400.00	00.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-84,300.00	00.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,681,500.90	20,065,218.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,382,304.14	-8,432,777.70
393	Биет бус хөрөнгө	220,000.00	165,000.01
39301	Програм хангамж	220,000.00	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-54,999.99
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	47,666,687.36	27,687,991.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	261,000.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	261,000.00	00.00
413	Өглөг	261,000.00	00.00
4136	Бусад өглөг	261,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	261,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	47,405,687.36	29,463,647.10
51	Засгийн газрын хувь оролцоо	47,405,687.36	29,463,647.10
512	Хуримтлагдсан үр дүн	47,405,687.36	29,463,647.10
51210	Өмнөх үеийн үр дүн	47,405,687.36	47,405,687.36
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-19,717,695.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	47,666,687.36	27,687,991.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	102,444,786.90	47,406,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,207,186.90	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	55,207,186.90	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	55,207,186.90	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	55,207,186.90	253,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	47,237,600.00	47,153,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,237,600.00	47,153,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,237,600.00	47,153,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	55,039,099.54	67,124,295.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,039,099.54	67,124,295.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,218,242.41	65,808,789.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,306,085.58	34,110,952.61
210101	Үндсэн цалин	29,930,782.48	33,899,516.73
210102	Нэмэгдэл	375,303.10	211,435.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,006,427.66	4,668,695.30
210201	Тэтгэврийн даатгал	2,904,799.79	3,256,416.57
210202	Тэтгэмжийн даатгал	352,370.57	314,005.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	281,716.44	289,687.55
210204	Ажилгүйдлийн даатгал	63,705.30	109,144.35
210205	Эрүүл мэндийн даатгал	403,835.56	699,441.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	953,379.63	593,445.70
210301	Гэрэл, цахилгаан	463,978.56	80,900.70
210302	Түлш, халаалт	489,401.07	512,545.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,561,200.00	9,474,982.78
210401	Бичиг хэрэг	562,400.00	627,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,310,000.00	1,889,818.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	407,900.00	442,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	280,900.00	418,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	6,097,964.78
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	261,000.00	1,791,000.00
210604	Урсгал засвар	261,000.00	1,791,000.00
2107	Томилолт, зочны зардал	204,000.00	1,279,000.00
210702	Дотоод албан томилолт	204,000.00	1,279,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	304,450.00	162,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	92,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	63,550.00	10,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,900.00	27,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	33,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний	00.00	00.00

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,621,699.54	13,728,713.02
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,621,699.54	13,728,713.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,820,857.13	1,315,506.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	458,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	458,300.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,362,557.13	1,315,506.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,362,557.13	1,315,506.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>47,405,687.36</u>	<u>-19,717,695.80</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,062,166.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,062,166.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,062,166.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>45,343,521.36</u>	<u>-19,717,695.80</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	47,405,687.36	47,405,687.36
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	47,405,687.36	47,405,687.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	47,405,687.36	47,405,687.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-19,717,695.80	19,717,695.80
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	27,687,991.56	27,687,991.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	47,237,600.00	47,153,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	47,237,600.00	47,153,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,237,600.00	47,153,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,237,600.00	47,153,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	47,237,600.00	47,153,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,237,600.00	47,153,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,416,742.87	45,838,093.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,306,085.58	34,098,747.91
210101	Үндсэн цалин	29,930,782.48	33,388,606.92
210102	Нэмэгдэл	375,303.10	710,140.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,006,427.66	4,680,900.00
210201	Тэтгэврийн даатгал	2,904,799.79	3,294,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	352,370.57	346,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	281,716.44	277,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	63,705.30	103,632.74
210205	Эрүүл мэндийн даатгал	403,835.56	659,167.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	953,379.63	593,445.70
210301	Гэрэл, цахилгаан	483,379.63	80,900.70
210302	Түлш, халаалт	470,000.00	512,545.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,657,400.00	3,990,000.00
210401	Бичиг хэрэг	618,700.00	678,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,310,000.00	2,520,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	407,900.00	442,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	320,800.00	350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,026,000.00	1,026,000.00
210604	Урсгал засвар	1,026,000.00	1,026,000.00
2107	Томилолт, зочны зардал	204,000.00	1,279,000.00
210702	Дотоод албан томилолт	204,000.00	1,279,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	263,450.00	170,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	63,550.00	10,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,900.00	27,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	33,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,820,857.13	1,315,506.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	458,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	458,300.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,362,557.13	1,315,506.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,362,557.13	1,315,506.39
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,152,600.00	45,838,093.61	1,314,506.39	97.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,152,600.00	45,838,093.61	1,314,506.39	97.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,110,900.00	45,838,093.61	1,272,806.39	97.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,674,800.00	34,098,747.91	576,052.09	98.34
210101	Үндсэн цалин	33,414,800.00	33,388,606.92	26,193.08	99.92
210102	Нэмэгдэл	1,260,000.00	710,140.99	549,859.01	56.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,679,900.00	4,680,900.00	(1,000.00)	100.02
210201	Тэтгэврийн даатгал	3,294,000.00	3,294,000.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	345,700.00	346,700.00	(1,000.00)	100.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	277,400.00	277,400.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	69,300.00	103,632.74	(34,332.74)	149.54
210205	Эрүүл мэндийн даатгал	693,500.00	659,167.26	34,332.74	95.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,038,000.00	593,445.70	444,554.30	57.17
210301	Гэрэл, цахилгаан	525,000.00	80,900.70	444,099.30	15.41
210302	Түлш, халаалт	513,000.00	512,545.00	455.00	99.91
2104	Хангамж, бараа материалын зардал	3,990,000.00	3,990,000.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	675,000.00	678,000.00	(3,000.00)	100.44
210402	Тээвэр, шатахуун	2,520,000.00	2,520,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	445,000.00	442,000.00	3,000.00	99.33
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	350,000.00	350,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,026,000.00	1,026,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,026,000.00	1,026,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,350,000.00	1,279,000.00	71,000.00	94.74
210702	Дотоод албан томилолт	1,350,000.00	1,279,000.00	71,000.00	94.74
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	352,200.00	170,000.00	182,200.00	48.27
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,900.00	27,000.00	28,900.00	48.30
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,700.00	43,000.00	6,700.00	86.52
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,153,600.00	47,153,600.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,153,600.00	47,153,600.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	47,153,600.00	47,153,600.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	4.00	4.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00	-	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн анги нь аймгийн хэмжээнд ойг хамгаалах, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн байгаль орчны хамгааллын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн санг гэрээгээр иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлэх, мэргэжил арга зүйг зөвлөгөө өгөхөд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн даргын тушаалаар Байгууллагын дотоод журмыг баталсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн дотоод аудитыг Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын

гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн анги нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 47,111.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 706.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 530.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Ойн тухай хууль, Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд орон нутгийн төсвөөс 47,152.6 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрүүлээгүй байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 23,490.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1,795.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 240.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 29,681.5 мянган төгрөгийн бусад хөрөнгө, 220.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 55,427.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Тайлант онд Аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгийн данснаас 9,856.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 4,960.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 5,112.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 709.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дангүй байна. Бараа материал 709.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 28,754.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	-	-	-
Урьдчилгаа			-
Бараа материал	861.2	709.2	(152.0)
Үндсэн хөрөнгө	46,805.5	26,978.8	(19,826.7)
Нийт хөрөнгө	47,666.7	27,688.0	(19,978.7)
Өр төлбөр	261.0	-	(261.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	47,405.7	27,688.0	(19,717.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	47,666.7	27,688.0	(19,978.7)

Бараа материалын дансны үлдэгдэл 709.2 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 152.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,688.0 мянган төгрөг болж 19,978.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 9,856.7 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 27,688.0 мянган төгрөг болж 19,978.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 47,153.6 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 47,153.6 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 47,153.6 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 47,153.6 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 45,838.1 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 1,314.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 45,838.1 мянган төгрөг буюу 97.2 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрүүлээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 62 дугаар тогтоолоор БОАЖГ-аас балансаас баланст шилжүүлсэн 18 нэр төрлийн 22,269.8 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил шилжүүлснээс 860.3 мянган төгрөгийн үнэ бүхий 2 нэр төрлийн үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө дансанд 23,490.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1,795.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 240.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 29,681.5 мянган төгрөгийн бусад хөрөнгө, 220.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 55,427.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Тайлант онд Аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгийн данснаас 9,856.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 4,680.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 279.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,147.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 878.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 287.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 878.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулав. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 62 дугаар тогтоолоор БОАЖГ-аас балансаас баланст шилжүүлсэн 18 нэр төрлийн 22,269.8 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил шилжүүлснээс 860.3 мянган төгрөгийн үнэ бүхий 2 нэр төрлийн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-д "бүх орлого" гэсэнтэй нийцэхгүй, "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлантай тулган шалгахад Засгийн газрын хувь оролцоо, Нийт өр төлбөрийн дүн 18.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 287.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/13 дугаар тушаалын дагуу үр дүнгийн урамшуулалт цалин олгохдоо хавсран ажилладаг 1 албан хаагчийн үр дүнгийн урамшууллыг алдаатай тооцоолсны улмаас 287.2 мянган төгрөгийн урамшуулалт цалин илүү олгосон нь: НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Байгууллагын удирдлага нь жилийн эцсийн тооллого гүйцэтгэх тушаал гаргаагүй, тооллогыг гүйцэтгэсэн боловч тооллогын үр дүнг хэлэлцээгүй, тооллогыг бүрэн баталгаажуулаагүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийг тухай хуулийн 72 дугаар

зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй нийцэхгүй, "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг бодитой гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн анги	5	1,147.5	2	878.7	1	287.2	1	-	1	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn